

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23-Р СУРГУУЛИЙН

БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ: Ж.ЦЭЦЭГТУЯАГИЙН 2018-2019 ОНЫ

ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ТӨЛӨВШИЛ: Оролцоо

- Ангийн нийт сурагчдыг сургуулийн дэг журмыг баримталж ,орчинд дасан зохицох ,сурах арга барил эзэмшүүлэх үүднээс сургалтыг тогтмол хүүхдийн сонирхолд нийцүүлэн сургалтыг зохион байгуулж байна. Ингэснээр хүүхдүүдийн хичээлд оролцох идэвхи нь сайжирч байна
- Сургуулийн орчинд ба сургалтын явцад биеэ зөв авч явах үүднээс ангийн болон сургуулийн дэгийг боловсруулан дэгийг тогтмол таниулан ажиллаж байна. Үүний үр дүнд сурагчид маань сургуулийн орчинд чанга дуугаар ярихгүй, гүйж харайх нь багассаар байна
- Анги болон сургуулиас зохиогдсон ажил . тэмцээн уралдаанд сурагчдыг хамруулан идэвх санаачлагатай оролцож байна.



Дадал хэвшил

- Ангийн сурагчид дүрэмт хувцсаа тогтмол цэвэр сайхан өмсөж хэвшсэн. Биеийн тамирын хичээлийг тасалдаг сурагч нэгч байж болохгүй гэсэн шаардлага тавьж ажилладаг.



- 1 ба 3-р ээлжийн хооронд жагсаж хэвшин, хичээл тарахдаа жагсаалаар гарах чадварыг сайн хэвшүүлж байна.

- Гадуур хувцсаа даавуун уутанд хийж өлгүүрт өлгөж хэвшлээ. Энэ нь ороолт, малгай, бээлий зэрэг зүйлээ хамт хийдэг тул эмх цэгцтэй байдал суралцах давуу талтай.
- Хичээлийн хэрэглэгдэхүүнийг тогтмол авч ирэх, ариг гамтай, зөв хэрэглэх тал дээр зөвлөн тусалж анхаарал хандуулан ажиллаж байна.
- Үдийн цайгаа уухаас өмнө гарын ариутгалыг тогтмол хийж хэвшсэн. Жижүүр сурагч малгай, хормогч, ханцуйвч өмсөж жижүүрийн үүрэгт ажлаа тогтмол хийж хэвшлээ.
- Даваа гараг бүрийн 1-р цаг дээр төрийн дуулал дуулж хэвшлээ.
- 4-р цагийн завсарлагаанаар хөдөлгөөнт дасгал хийж хэвшиж байна.

Зан чанар

- Сургуулийн дэгийг баримтлах тал дээр бие биендээ шаардлага тавихдаа аядуу зөөлөн дуугаар, зөв хандлагатай шаардлага тавих арга барилд суралцаж байна. Зан харьцааны доголдол гаргасан Н. Хантүшигт ТӨЛӨВШЛИЙН шар хуудас өгч ,эцэг эхтэй нь уулзаж ярилцлаа. Хичээлийг чөлөө зөвшөөрөлгүй тасалсан А. Мөнхжин , Т.Эгшиглэн Б.Анар-Эрдэнэ нарт ТӨЛӨВШЛИЙН шар хуудас өгч сануулга өглөө.
- Баярласан, талархсан сэтгэлээ зөв боловсон илэрхийлэн сурах үүднээс үдийн цайгаар үйлчилдэг гал тогооны эгч нартаа талархлын үгсийг хэлж сурч байна
- Сургуулийн багш ,ажилтан болон өөрөөсөө ахмад хүнтэй мэндлэх хүндлэх зан чанарыг сайн эзэмшиж байна.

- Сурагчдын оролцооны ур чадвар өмнөх ангид байснаас илүү ахиц гарсан хүүхэд хүүхдэдээ шаардлага тавьж сурч байна. Ангийн дарга салаан даргын тавьсан шаардлагыг биелүүлэх ёстой гэдгийг ухамсарладаг болсон.
- Жижүүр багшийн үүрэгт ажлыг хуваарьтай үедээ тогтмол 29%-30% үнэлгээтэй хийж гүйцэтгэсэн.
- Сонирхолын судалгаа, авьяасын, секц дугуйлангийн судалгаа авч анализ хийсэн.

Хичээлээс гадуурх ажилд эцэг эхийг татан оролцуулсан байдал

--- Алтан намар үйл ажиллагаа-----

1-р баг



--- Шинэ жил угтсан Хурдан уншигч, хурдан бодогч, цэвэр бичигтэн шалгаруулах уралдаан зохиож дүгнэх үйл ажиллагаа ---

2-р баг



--- Уншвал зохих үлгэрээр ЖҮЖИГЧИЛСЭН тоглолт хийх, мөн БЯЦХАН НОМ хийлгэх ажлыг зохион байгуулж 5-р баг 1-р байр эзэлсэн. Шилдэг номуудаар сургуулийн 2давхарт үзэсгэлэн гаргасан. --- -3-р баг

---Сурагчдын танин мэдэхүйг хөгжүүлэх зорилгоор “ЗОО ПАРК” үзүүлсэн



2-р ангийн эцэг эхчүүдийн дунд зохион байгуулсан” ГАР БӨМБӨГ”-ийн тэмцээн
4-р баг

----Уншсан номын тэмдэглэл хөтлөх аян

---- Хурдан уншигч

----Уран уншигч шалгаруулах.

Танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулах ажлыг ---- 5-р багийн эцэг
эхчүүд зохион байгууллаа.

<https://youtu.be/7HSHVyAyK1c>

Сурагч Эрдэнэбилигийн аав Даринчулуун Эцэг эх гэж хэн бэ? Илтгэл бичиж
хэлэлцүүлэгт оролцсон.

Хүүхэд хамгаалал ёс зүйн дүрмийн хүрээнд сургуулийн эмч Соёлмаа, Эрүүл ахуйч эмч Буянхишиг нар мэдээлэл хийсэн. Аюулгүй байдлыг хангах зорилгоор ангийн хогийн шүүрний иш, шкафын шилэнд хуулга наасан. Ангийн ариун цэвэр болон сурагчдын хувийн ариун цэвэрт хяналт тавин ажилладаг.

2 СУРАГЧ НЭГ БҮРИЙН СУРЛАГЫН АМЖИЛТ :

Гарсан ахиц:


Гарааны үнэлгээ:

- Хичээлийн жилийн эхэнд монгол хэл, математик, Хүн-Орчин хичээлүүдээр гарааны шалгалт авч анализ хийлээ.
- Монгол хэл , Математикийн хичээлийн хоцрогдолтой сурагч Хантүшиг, Тулуй ,Мөнхбаяр нарын эцэг эхтэй хамтарч ажилласнаар сурагчдад ахиц гарч байна.
- Ангийн 18 сурагч Математик сонины нэрэмжит намрын сорилго IQ олимпиадад оролцлоо. Үүнээс: Сурагч: Б.Эрмүүн “ТОП” үнэлгээ, сурагч : Г. Чингүүн, О.Гэгээ нар амжилттай оролцон дунджаас дээгүүр үнэлгээтэй шалгагдсан.

АВЬЯАС ЧАДВАРЫГ НЭЭСЭН БАЙДАЛ:

- Энэ хичээлийн жилийн эхний хагаст ангийн нийт сурагчид зөв алдаагүй, цэвэр сайхан бичих чадварт суралцаж байна.
- Ангийн сурагчдын эцэг эхээс авьяасын судалгаа аван нэгтгэн дүгнэлээ.
- Ангийн сурагчдын 33% нь буюу 22 сурагч дугуйлан секцэнд хамрагдсан байна.

- Ном солилцож унших аян өрнүүллээ.
- Уншсан номын тэдэглэл хүүхэд бүрээр хөтлүүлж чанартай сайн хөтөлсөн сурагчийг шалгарууллаа.



- Бүтээлийн үзэсгэлэн нийт 5 удаа гаргасан.





- Moodle sistemд хөтөлбөр төлөвлөгөө, ээлжит, нэгж оруулах

АВЪЯАСЫГ ХӨГЖҮҮЛСЭН БАЙДАЛ:

- Ангийн нийт сурагчид унших хурдаа ахиулах зорилгоор 3 удаа минутны уншлага авч ангийн хурдан уншигч сурагчдыг шалгаруулж “ӨРГӨМЖЛӨЛ” гардууллаа 1-р шат 12 дугаар сард
- Ангийн хурдан бодогч, Цэвэр сайхан бичигтэн сурагчдыг шалгаруулж урмшууллаа.
- 3н дуу шинээр сургалаа. Мөн шүлэг цээжлэн уран тод унших аргад суралцаж байна.
- Уншсан үлгэрээр жүжигчилсэн тоглолт хийсэн
- Бяцхан ном хийлгэж үзэсгэлэн гаргасан.
- Уншсан номын тэмдэглэл хөтлөх аян зарлаж дүгнэхэд сурагч Х.Ану –Үжин тэргүүн байр эзэллээ.



- Хүүхэд бүр 5 шүлэг уншиж ангийн уран уншигчаар М. Хулан шалгарлаа.



- 2-р шатны уншлагын уралдаан зарлаж Б.Эрмүүн ангийн хурдан уншигчаар шалгарлаа.



- Танин мэдэхүйн АХА тэмцээн зохиогдож 1-р байр З.Энэрэл

2-р байр Б.Эрмүүн



- Навчин наамал, Усан будгаар урлахуй, дүрсээр бүтээл урлах зэрэг бүтээлээр нь бүтээлийн үзэсгэлэн гарган эцэг эхэд нь танилцуулав
- Ардын ёс заншил
- Усан будгаар урлахуй
- Баримлын шавраар урлах зэрэг бүтээлээр үзэсгэлэн гаргасан.
- 20 сурагч “Сүбээдэй хүү” ёс суртахууны сургамжит жүжиг үзүүлсэн



- Номын өргөөтэй танилцаж уншлага хийж номын тэмдэглэл хөтөллөө.



Сургууль олон нийтийн ажилд оролцсон байдал

№	Хугацаа	Үйл ажиллагааны нэр	Зохион байгуулсан газар	Үүрэг оролцсон байдал
1	9 сар	Багш нарын буухиа тэмцээн	23-р сургууль	Багаараа 1-р байр
2	10 сар	Мод тарих	23-р сургууль	Сургуулийн ногоон байгууламжийг цэвэрлэсэн
3	10 сар	Дадлага удирдах сургалт	Багшийн сургууль	Дадлага удирдах талаарх мэдлэгээ сайжрууллаа
4	10 сар	Мүүдль сургалт	23-р сургууль	Мүүдль системийг ашиглах аргад суралцсан
5	10 сар	Цэнэглэх цаг	23-р сургууль	Ажлын байрандаа хэрхэн сэтгэл ханамжтай байх мэдлэгийг олж авсан
6	9,10,11, 12 сар	Сургуулийн болон ЗАН хурал	23-р сургууль	Цаг үеийн байдлын талаарх мэдээллийг тогтмол авдаг
7	12 сар	Мүүдль сургалт	23-р сургууль	Мүүдль системийг ашиглан тест боловсруулах аргад суралцсан
8	12 сар	Цэнэглэх цаг	23-р сургууль	Хөдөлгөөний дутагдлын талаар мэдлэгээ нэмэгдүүллээ.
9	1 сар	ЧД гийн бага боловсролын багш нарын тэмцээн	140-р сургууль	Волейбол , буухиа тэмцээний төрлүүдэд амжилттай оролцсон
10	1сар	Судлагдахууны	47-р сургууль	Дүрслэх урлаг хичээлийн

		сургалт		суплагдахууны сургалт.
11	2сар	Цэнэглэх цаг	23-р сургууль	Эрүүл мэнд
12	3 сар	ЧД-гийн эцэг эх сурагчдын дунд зохиогдсон црлагийн наадам	50-р сургууль	Багийн дүнгээр 2-р байр
13	4 сар	2д ангийн эцэг эхийн дунд зохиогдсон гар бөмбөгийн тэсцээн	23-р сургууль	Эцэг эхийн зүгээс үүргээ амжилттай биелүүлж оролцсон
14	5сар	Moodle сургалт	23-р сургууль номын сан	Ангийн мэдээ мэдээлэл оруулах

БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ:

Эцэг эхийн сэтгэл ханамж:

- Эцэг эхийг сургалтын үйл ажиллагаатай танилцуулах зорилгоор улиралд 1-2 удаа эцэг эхийн хурлыг зохион байгуулан санаа бодлоо хуваалцан хэрхэн ажиллах ямар ажил зохион байгуулах тал дээр зөвөлгөө өгөн эцэг эхээс гаргасан оновчтой санаа бодлыг сургалтандаа хэрэгжүүлж байна.
- Эцэг эхээ таван багт хуваан улирал бүр эцэг эхийн оролцоотой ажлуудыг төлөвлөн төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгууллаа.

Үүнд: I-р баг Эцэг эхийн нэг өдөр, “Алтан намар” сэдэвт өдөрлөг

- II баг сурагчдын дунд минутны уншлага, урлаг наадамд бэлтгэн оролцох арга хэмжээг зохион байгуулах

- III баг шинэ жил угтсан уралдаан ангийн шилдэг сурагчдыг шалгаруулах, Үлгэрээр жүжигчилсэн тоглолт хийх ажлыг тус тус зохион байгуулан явууллаа.
- Үдийн цайны амталгаат өдөрлөгт эцэг эхийг хамрууллаа.

Сурагчийн сэтгэл ханамж:

- Ангийн сурагчдын бүтээлээр ангидаа бүтээлийн үзэсгэлэн гарган урамшуулан магтан сайшаан ажиллаж байна.
- Ангидаа цэвэр сайхан бичигтэн, хурдан уншигч, хурдан бодогч сурагчдыг шалгаруулав.

ЭРҮҮЛ МЭНД:

- Гар угаах өдрийг тохиолдуулан “Гараа хэрхэн зөв угаах “ талаар сургалт зохион байгуулав
- Амны хөндийн ариун цэврийн талаарх сургалтыг зохион байгууллаа \1-р багийн эцэг эхийн тусламжтайгаар \
- Сургуулийн эмчтэй хамтран ангийн сурагчдыг 100% өндөр жингийн үзлэгт хамрууллаа
- 7-н настны товлотт вакцинд 63 сурагч хамрууллаа
- 4-р цагийн завсарлагаанаар хөгжимт дасгал хийж хэвшиж байна.
- Өдөр бүр ВИТАМИНЖҮҮЛЖ 3, 3-н үрэл идүүлж хэвшсэн.

ЭРҮҮЛ ХАРИЛЦАА:

- Өөрөөсөө ахмад ба багш ажилчидтай мэндлэх чадварыг эзэмшиж байна
- Баярлалаа үгийг зөв үед, зөв хэлж хэвших тал дээр ангийн багшийн зүгээс анхаарал хандуулан ажиллаж байна.
- Үдийн цайгаар үйлчилдэг гал тогооны эгч нартаа талархлын үгийг хэлж хэвшсэн.

ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИН:

- Сурагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор хичээлийн улирлын амралт эхэлсэнтэй холбогдуулан хүүхдийг эцэг эхийн хяналтанд хүлээлгэн өгөн эцэг, эхээр гарын үсэг зуруулан баталгаажууллаа
- Ангийн сурагчдыг Гараас гарт хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж байна.
- Ангийн сурагчдыг 100% цүнхний цацруулагчтай болгосон
- Сургуулийн зүгээс өгч байгаа анхааруулга сануулгыг тогтмол сурагчид болон эцэг эхэд танилцуулж гарын үсгээр баталгаажуулж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ:

Ж.Цэцэгтуяа